



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХАНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 11 өдөр

Дугаар А/43

Ханх сум

Г Сумын мэргэн цол олгох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, Үндэсний баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А/257 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ
НЬ:

1.Тулгар төрийн 2233, Их Монгол Улс байгуулагдсаны 818, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 113, Ардын хувьсгалын 103 жилийн ой улсын баяр наадмын “Үндэсний сурын харваа”-ны эрэгтэй төрөлд 1-р байр эзэлсэн тул Жаргалсайханы Мөнхсайханд сумын “Мэргэн” цол олгосугай.

2.Цолны дагалдах мөнгийг баяр наадмын зардлын сангаас тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Э.Бямбасүрэн)-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Б.Баттүвшин)-д даалгасугай

ДАРГА Л.ДАВААБАЯР

